



ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2022

Эрхэм зорилго:

Хэрэглэгчийн хэрэгцээт
цахилгаан, дулааны
эрчим хүчийг үйлдвэрлэн
хэвийн найдвартай
хангах



Дорнод аймаг, Чойбалсан хот



(976) 7058 4545



info@ees.energy.mn

www.ees.energy.mn





Агуулга

01

Удирдлага, хүний нөөц

4-21

02

Үйлдвэрлэлийн үзүүлэлт

22-25

03

Техник, эдийн засгийн үзүүлэлт

26-41

04

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт

42-44

05

Технологийн сахилга

45-54

06

Хэрэглэгчдэд үйлчлэх төв

55-66

07

ХАБЭА, байгаль орчин, эрүүл ахуй

67-75

08

Дотоод хяналт

76-77

09

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

78-83

10

ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төслийн ажлын явц

84-89





**"ДБЭХС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал
МУ-ийн Эрчим хүчний зөвлөх инженер
Гэндэнжамц ОТГОНБААТАР**



"ДБЭХС" ТӨХК нь Зүүн бүс нутгийн Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, суурин газрын 30390 айл өрх, 2845 төр болон хувийн хэвслийн аж ахуйн нэгж, албан байгууллага, 17 уул уурхайн ордын баяжуулах, олборлох үйлдвэрийг цахилгааны эрчим хүчээр, Чойбалсан хотын 887 аж ахуй нэгж, 7426 айл өрхийг дулааны эрчим хүчээр ханган ажиллаж байна.

2022 онд манай компани 242.7 сая.кВтц цахилгаан эрчим хүч боловсруулж төлөвлөгөөг 108.4%-иар, 278.1 сая.кВтц цахилгаан эрчим хүч түгээж төлөвлөгөөг 105.8 хувиар, дулааны эрчим хүч 326.0 мян.Гкал түгээж төлөвлөгөөг 103.0 хувиар, борлуулалтын орлогын төлөвлөгөөг 4.2 тэрбум төгрөгөөр буюу 109.1 хувиар тус тус давуулан биелүүлж, батлагдсан техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг 82.3 хувиар биелүүлсэн амжилттай ажилласан байна.

2022-2023 оны өвлийн бэлтгэл ажлыг хангах, тоноглолуудын их болон урсгал засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-ний ажлуудыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэснээр үйлдвэрлэлийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай уялдуулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөт зорилтыг бүрэн биелүүлж ажилласан.

Станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төслийн ажил амжилттай үргэлжилж өнөөдрийн байдлаар тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 96 хувьтай, барилга байгууламжийн гүйцэтгэл 54 хувьтай хийгдээд байна.

1

УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

“ДБЭХС” ТӨХК нь Монгол Улсын цахилгаан эрчим хүчний зах зээлийн 3.8%, дулааны эрчим хүчний 2.1%-ийг хангадаг зүүн бүс нутгийн эдийн засгийн чухал ач холбогдол бүхий аж ахуйн нэгж юм.

“ДБЭХС” ТӨХК-ийн эзэмшлийн 100% нь төрийн мэдэлд байгаа ба компанийн менежмент, үйл ажиллагааны удирдлага Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөллийг бүрдүүлэх үүргийг Эрчим хүчний яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хангаж байна.

“ДБЭХС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус 3, төрийн төлөөлөл болох 6 гишүүнээс бүрдсэн 9 гишүүнтэй.

ТУЗ нь компанийг стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагыг хянах үүргийн хүрээнд компанийн эрх бүхий албан тушаалтны мэдээллийг тогтмол сонсож, компанийн үйл ажиллагааны онцлог, шуурхай байдлыг хангах чиглэл баримтлан Компанийн тухай хууль, компанийн дүрмийн хүрээнд сайн засаглалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлд гол анхаарал хандуулж ажилладаг.

Өнгөрсөн хугацаанд буюу 2022 оны байдлаар Төлөөлөн удирдах зөвлөл 13 удаа хуралдаж, нийт 27 тогтоол шийдвэр гаргасан ба энэ хугацаанд Аудитын хороо хамаарах асуудлаар 3 удаа, цалин, урамшууллын хороо 2 удаа, нэр дэвшүүлэх хороо 1 удаа тус тус хуралдаж, үүрэг даалгавар, зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөл нь “ДБЭХС” ТӨХК-ийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагааг чанаржуулах, компанийн эдийн засаг, санхүүгийн байдлыг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд анхааран ажиллаж байна.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Ж.ЖАНАРБААТАР

ТУЗ-ийн дарга



В.ДАРХАНБААТАР

ТУЗ-ийн гишүүн



Г.ТУЛГА

ТУЗ-ийн гишүүн



Б.ЭНХТӨР

ТУЗ-ийн гишүүн



Г.БАДАМЦЭЦЭГ

ТУЗ-ийн гишүүн



Э.ЖАРГАЛМАА

ТУЗ-ийн гишүүн



Э.ЭРДЭНЭХИШИГ

ТУЗ-ийн хараат бус
гишүүн



Д.ГАН-ОЧИР

ТУЗ-ийн хараат бус
гишүүн




Э.МӨНХ-ОРГИЛ

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Компанийн удирдлага зохион байгуулалт

Манай компани Дорнод, Сүхбаатар 2 салбар, Захиргаа удирдлага, Хангамж үйлчилгээ, Санхүү бүртгэлийн 3 хэлтэс, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Төлөвлөлтийн хэсэг, Дотоод хяналтын, Техник хяналтын, Инженерийн, Хамгаалалтын 4 алба, Түлш дамжуулах, Зуух, Турбин-Хими, Цахилгаан, Компьютер-дулааны хэмжүүр автоматик, Механик засвар, Цахилгаан шугам сүлжээ, Дулааны шугам сүлжээний нийт 8 цех, нэгжүүдийн зохион байгуулалттай, үйл ажиллагааны холимог бүтэцтэй ажил үйлчилгээ явуулдаг.

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН БҮТЦИЙН СИСТЕМ




Хүний нөөц, сургалт

Компани нь 2022 онд батлагдсан орон тооны дагуу 630 ажилтантай, үүнээс удирдлага 11, инженер техникийн ажилтан 123, ажилтан 486, Чойбалсангийн дулааны цахилгаан станцын 50МВт-ын төсөл хэрэгжүүлэх нэгжийн 10 инженер техникийн ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



2022 онд ажилд шинээр орсон 48, өөрийн хүсэлт, ажлын шаардлагаар албан тушаал өөрчлөгдсөн 38, өндөр насны тэтгэвэрт гарсан 7, жирэмсний болон амаржсаны чөлөө авсан 16, захиргааны санаачилгаар 1, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 28 хүн байна.

Сүүлийн 5 жилд ажилд орсон ажилтны тоо



Сүүлийн 5 жилд ажлаас гарсан ажилтны тоо



Сургалт

Компанийн хэмжээнд нийт 57 нэр төрлийн 111.1 сая төгрөгийн сургалтын зардал төлөвлөгдсөнөөс 83.8 сая төгрөгийн 78% -ийн сургалтын гүйцэтгэлтэй гарсан.



2022 онд зэрэг ахихаар төлөвлөсөн 51 ажилтнаас 31 ажилтан мэргэжлийн зэргээ сайн дүнтэй ахиулж, төлөвлөгөө 61 хувь биелсэн.

Эрчим хүчний салбарын боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг оновчтой болгох хүрээнд “ДБЭХС” ТӨХК ЭХХТ-ийн Сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу хамтран ажилласан.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 27 дугаар зүйлийн 27, 3, 4 дэх заалтын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт ажилтны сургалтыг Дорнод аймгийн Политехник коллежийн сургуультай хамтран 3 өдрийн хугацаанд зохион байгуулж, сургалтад 450 ажилтан, шинэ ажилтнуудын сургалтад 59 ажилтан тус тус хамрагдсан.






“ЭХХТ” ТӨҮГ-ын Эрчим хүчний салбарын нэгдсэн лабораторийн мэргэжлийн комиссын “ГАГНУУРЧДЫГ АТТЕСТАТЧИЛАХ ЖУРАМ, MNS ISO 9606-1:2021 СТАНДАРТ”-ын дагуу шалгалтыг зохион байгуулсан.



Хөдөлмөрийн харилцаа

Хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан ажилтаны тоо

Б тушаалын ангилал



Компанийн захиргаанд 2022 онд нийт 372 өргөдөл, хүсэлт ирсэнээс чөлөө хүссэн 130, урамшуулал, хөнгөлөлт, тэтгэмж хүссэн 95, буцалтгүй тусламж 29, ажилд орохыг хүссэн 53 өргөдлийг шийдвэрлэсэн.

Нийгмийн хариуцлагын хүрээнд:

Дорнод аймгийн Хэрлэн сумын “Үүлэн балет” бүжгийн клубийн дэргэдэх Өсөх ирээдүй хамтлаг нь АНУ-д болох Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь компанийн ажилтнууд 5.0 сая төгрөгийг хандивласан.



Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын захирамжаар байгууллагын орчин болон Хэрлэн голын дагуух ногоон бүс цэвэрлэсэн.





Спорт уралдаан, тэмцээн:

Ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын ур чадварыг нь дээшлүүлэх, хамт олны эв нэгдлийг бэхжүүлэх зорилгоор дараах спорт уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсан.

- Ашиглалтын нэгдсэн ээлжүүдийн олон төрөлт спортын тэмцээн
- Засварчдын олон төрөлт спортын тэмцээн
- Цэргийн баярыг угтаж Үндэсний бөхийн барилдаан
- Цехийн дарга нарын нэрэмжит ИТА нарын дунд спортын олон төрөлт тэмцээн
- ЭХС-ын 100 жилийн ойг тохиолдуулан Сагсанбөмбөгийн тэмцээн
- ЭХС-ын 100 жилийн ойг тохиолдуулан Волейболын тэмцээн
- Бадминтоны аварга шалгаруулах тэмцээн



Эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан спортын 6 төрлөөр зохион байгуулагдсан тэмцээнд баг тамирчид амжилттай оролцсон.





Шагнал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Эрчим хүчний салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажилласан "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК-ийн Инженерийн албаны дарга Б.Бямбаа төрийн дээд одон медаль "АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЪЯАТ АЖИЛТАН" цолоор шагнагдсан.



МУ-ын Эрчим хүчний салбарын Шилдэг инженерээр "ДБЭХС" ТӨХК-ийн Инженерийн албаны Горим техник хяналтын инженер Ө.Од шалгарав.



2022 оны “ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА ХАМТ ОЛОН”

Монгол Улсын зүүн бүсийн хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулан, хэрэглэгчдэд цахилгаан дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн түгээх ажилдаа сэтгэл зүтгэл гаргаж мэргэжлийн өндөр төвшинд үр бүтээлтэй ажилласан амжилтыг нь үнэлэн Б.Даваажаргал даргатай Цахилгаан цехийн хамт олон болон Ч.Одбаяр даргатай Дорнод салбарын хамт олныг “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ийн 2022 оны **“ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА ХАМТ ОЛОН”** -оор тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.





Компанийн 2022 оны шилдэг тэргүүний ажилтнууд



1. **“Тэргүүний монтёр”** Г.Ариунболд (ЦШС-ний цехийн АШЗ-ын монтёр)
2. **“Тэргүүний ИТА”** С.Ганбаатар (Зуухан цехийн дарга)
3. **“Тэргүүний албан хаагч”** Л.Эрдэнэцэцэг (ЗУХ-ийн Архив бичгийн хэргийн ажилтан)
4. **“Тэргүүний машинч”** Ц.Одонтунгалаг (Зуухан цехийн машинч)
5. **“Тэргүүний ээлжийн мастер”** Э.Энхмаа (Цахилгаан цехийн ээлжийн мастер)
6. **“Тэргүүний оператор машинч”** Ш.Дэнсмаа (К-ДХА цехийн ДХХА-ийн ээлжийн засварчин)
7. **“Үйлчилгээний тэргүүний ажилтан”** Ц.Саранцэцэг (Турбин- Хими цехийн ТТАжилтан)
8. **“Борлуулалтын тэргүүний ажилтан”** Б.Ганбат (Дорнод салбарын байцаагч монтёр)
9. **“Тэргүүний жолооч”** Д.Ганбат (ХҮХ-ийн автограшийн жолооч),
10. **“Шилдэг ажилтан”** Ө.Од (ИА-ны ГТХ-ийн инженер)
11. **“Тэргүүний засварчин”** Э.Мягмаржав (Механик засварын цехийн засварчин)

Эрчим хүчний салбарын 100 жилийн ойн баярын медалийг 31 жилээс дээш жил ажилласан компанийн 76 ахмадад гардуулан өгсөн.



2

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үндсэн үйл ажиллагааны техник эдийн засгийн статистик үзүүлэлтүүд


Суурилагдсан хүчин чадал ашиглалт /хувь/






Энэ онд цахилгааны дээд ачаалал 36.7 МВт хүрч, суурилагдсан хүчин чадлаас давсан бол доод ачаалал зуны ачааллын горимд 15.0 МВт, өвлийн ачааллын горимд 26.2 МВт байна.

Цахилгаан ачаалал /МВт/




Боловсруулсан ЦЭХ /сая.кВт.ц/



2022 оны гүйцэтгэлээр дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний 13.22% буюу 32.1 сая.кВт.ц ЦЭХ-ийг дотоод хэрэгцээндээ хэрэглэж ажилласан ба энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон зорилтот түвшний төлөвлөгөөнөөс 0.64 пунктээр, 2021 оноос 0.48 пунктээр бууруулсан.

Дотоод хэрэгцээний ЦЭХ /хувь/



Түгээсэн ЦЭХ /сая.кВт.ц/






Түлшний хувийн зарцуулалтын бууралт нь:

ТГ №3,4-ийн конденсаторын гуулин хоолой солих ажил хийгдэж, сольсноос хойш турбины ачаалал авалт сайжирсан, вакум дээшилж, уурын хувийн зарцуулалт буурсан зэргээс голлон нөлөөлсөн.

Түлшний хувийн зарцуулалт



Түгээсэн ДЭХ /мян.ГКал/



3

ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

“ДБЭХС” ТӨХК нь диспетчерийн үндэсний төвийн баталсан төлөвлөгөөг үндэслэн 223.8 сая.кВтц цахилгаан эрчим хүч боловсруулж, дотоод хэрэгцээнд 14.47% буюу 32.37 сая.кВтц цахилгаан эрчим хүч хэрэглэн, ТБНС-ээс 71.3 сая.кВтц цахилгаан эрчим хүч худалдан авч, 262.9 сая.кВтц цахилгаан эрчим хүч, 316.5 мян. Гкал дулааны эрчим хүч түгээхээр төлөвлөсөн.

2022 оны гүйцэтгэлээр 242.7 сая.кВтц цахилгаан эрчим хүч түгээж төлөвлөгөөг 15.2 сая.кВтц буюу 5.8 %-иар, 326.0 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж төлөвлөгөөнөөс 9.5 мян.Гкал буюу 3.0%-иар тус тус давуулан биелүүлж ажилласан. Үүний үр дүнд эрчим хүчний борлуулалтаас 50.5 тэрбум төгрөг, бусад орлогоос 1.6 тэрбум төгрөг олж нийт 52.2 тэрбум төгрөгийн орлого олж борлуулалтын орлогын төлөвлөгөөг 9.1%-иар буюу 4.2 тэрбум төгрөгөөр өсгөсөн..

2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг Эрчим хүчний сайдын А/20 дугаар тушаалаар 2022.01.07-ны өдөр батлуулан ажиллаж байгаад, эрчим хүчний түгээлтийн өөрчлөлтийг үндэслэн ТУЗ-ийн 13 тоот тогтоолоор 2022.05.13-ны өдөр батлуулан, Эрчим хүчний сайдын А/123 дугаар тушаалаар 2022.06.08-ны өдөр нэмэлт өөрчлөлтийг баталгаажуулж мөрдөн ажилласан.



2022 ОНЫ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022		Өөрчлөлт	
			Төл	Гүйц	Биет	Хувиар
1	ЦЭХ боловсруулалт	сая. кВтц	223.8	242.7	18.9	108.5%
2	ДХЦЭХ хувиар	хувь	14.47%	13.22%	-1.25%	109.5%
	биет	сая. кВтц	32.37	32.07	(0.30)	99.1%
Нийт түгээх ЦЭХ		сая. кВтц	262.9	278.1	15.2	105.8%
3	Үүнээс: Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	191.4	210.6	19.2	110.1%
	ХАЦЭХ-ДҮТ	сая. кВтц	71.3	67.3	-4.0	94.4%
	Импортын ЦЭХ	сая. кВтц	0.244	0.177	-0.067	72.5%
4	Түгээх ДЭХ	мян.Гкал	316.50	326.0	9.5	103.0%
5	Түгээлтийн алдагдал хувиар	хувь	7.80%	7.96%	0.16%	98.0%
	биет	сая. кВтц	13.7	14.76	1.10	108.1%
6	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая. кВтц	249.2	263.4	14.1	105.7%
Нийт орлого		сая.төг	47,651.2	52,167.5	4,516.3	109.5%
7	Борлуулалтын орлого	сая.төг	46,332.4	50,558.1	4,225.7	109.1%
	Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	633.4	1,483.0	849.6	234.1%
	50 мВт ТХН-ийн орлого	сая.төг	685.4	126.3	(559.1)	18.4%
Нийт зардал		сая.төг	54,043.1	57,638.2	3,595.1	106.7%
8	Үйл ажиллагааны зардал	сая.төг	40,549.2	41,778.4	1,229.2	103.0%
	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая.төг	11,522.7	10,629.5	(893.2)	92.2%
	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	1,285.8	4,613.3	3,327.5	358.8%
	50 мВт ТХН-ийн зардал	сая.төг	685.4	617.1	-	0.0%
9	Татвар төлөхийн өмнөх ашиг, / алдагдал/	сая.төг	(6,391.8)	(5,470.7)	921.1	116.8%
10	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал /	сая.төг	(6,391.8)	(5,470.7)	921.1	116.8%
11	БО-ын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.882	0.905	0.023	102.6%
Нийт авлага		сая.төг	28,470.4	14,175.6	(14,294.8)	200.8%
12	ЭХ-ний авлага	сая.төг	2,292.5	1,271.7	(1,020.8)	180.3%
	бусад	сая.төг	26,177.9	12,903.9	(13,274.0)	202.9%
Нийт өглөг		сая.төг	67,390.3	50,567.4	(16,822.9)	133.3%
13	УХӨТ	сая.төг	62,490.3	41,951.3	(20,539.0)	149.0%
	БХӨТ	сая.төг	4,900.0	8,616.1	3,716.1	56.9%
14	Нийт ажиллагсад	ширхэг	620	619	(1)	100.2%
15	Нийт цалингийн сан	сая.төг	15,749.63	15,901.45	151.82	101.0%
16	Жишмэл тулшний ЦЭХ хувийн зарцуулалт	гр/кВтц	640.36	610.4	(30.00)	104.9%
	ДЭХ	кг/Гкал	192.90	191.4	(1.5)	100.8%
17	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	7,049.7	5,938.2	(1,111.6)	84.2%

Нийт орлого /тэрбум.төг/




Нийт зардал /тэрбум.төг/






Борлуулалтын орлого /тэрбум.төг/



Ашиг, алдагдал /сая.төг/




Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 он		зөрүү	хувь
		төлөв	гүйц		
1. Нийт боловсруулалт	мян.кВтц	223,755.0	242,693.7	18,938.70	8.5%
Үүнээс: ДХЦЭХ биетээр	мян.кВтц	32,370.0	32,072.1	(297.86)	-0.9%
хувиар	хувь	14.5%	13.2%	(0.01)	-8.7%
Цахилгаан түгээлт	мян.кВтц	262,904.00	278,116.78	15,212.78	5.8%
Дулаан түгээлт	мян.Гкал	316.5	326.0	9.50	3.0%
Усаар	мян.Гкал	316.5	326.0	9.50	3.0%
2. Санхүүгийн баланс					
Ашиг, Алдагдал	сая.төг	- 6,391.84	- 5,470.7	921.14	100.0%
Татварын зардал	сая.төг			-	#DIV/0!
Нийт орлого	сая.төг	47,651.23	52,167.50	4,516.27	9.5%
Цахилгааны орлого	сая.төг	42,018.02	45,782.41	3,764.40	9.0%
Дулааны орлого	сая.төг	4,278.58	4,747.85	469.27	11.0%
Импортын ЦЭХ-ний орлого	сая.төг	35.80	27.88	(7.92)	-22.1%
Бусад орлого	сая.төг	1,318.83	1,609.35	290.52	22.0%
Нийт өртөг зардал	сая.төг	54,043.07	57,638.20	3,595.13	6.7%
Цахилгааны зардал	сая.төг	39,454.7	39,420.8	(33.91)	-0.1%
Дулааны зардал	сая.төг	12,551.9	12,922.9	370.93	3.0%
Импортын ЦЭХ-ний өртөг	сая.төг	65.2	64.2	(1.03)	-1.6%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	1,971.2	5,230.4	3,259.14	165.3%
3. Ашиг алдагдалд нөлөөлсөн хүчин зүйлс					
Төлөвлөгөөнөөс давсан ашиг	сая.төг		- 5,470.7		
Төлөвлөгөөт ашиг, алдагдал	сая.төг				
Гүйцэтгэлийн ашиг, алдагдал	сая.төг		- 5,470.7		
- Нийт ү/а-ны зардлын хэтрэлтээс	сая.төг		- 3,595.1		
- үйлдвэрлэлийн бус ажиллагааны ашиг, алдагдал	сая.төг		- 3,621.0		
- Борлуулалтын давалтаас олсон ашиг	сая.төг		4,516.3		
- Валютын ханшны бодит бус алдагдал	сая.төг		- 3,391.4		
Нийт зардлын хэтрэлт, хэмнэлт					
а. Түлшний зардлын нөлөөлөл	сая.төг		1,608.9		
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтөөс	сая.төг		439.5		
Нүүрсний үнэ тарифын өсөлтөөс	сая.төг		1,230.0		
Мазут зарцуулалтын хэмнэлтээс	сая.төг		60.6		
б. Сэлбэг урсгал засварын зардлын хэтрэлт	сая.төг		150.0		
в. Цалин шимтгэлийн хэтрэлт	сая.төг		167.0		
г. Албан томилолтын зардлын хэтрэлт	сая.төг		49.8		
д. Борлуулалт маркетингийн зардлын хэтрэлт	сая.төг		36.2		
е. Шатахууны зардал	сая.төг		54.5		
ё. Бусдаар АҮГ зардлын хэтрэлт	сая.төг		27.0		
ж. Ашиглалтын ДХЦЭХ, ДЭХ-ний зардлын хэтрэлт	сая.төг		84.7		
и. Үл хөдлөх болон газрын татварын зардлын хэтрэлт	сая.төг		192.5		
й. Үйл ажиллагааны бус зардлын хэтрэлт	сая.төг		3,327.5		




Тайлант хугацаанд нийт 57,638.2 сая төгрөгийн зардалтай ажиллаж үндсэн үйл ажиллагаанд 52,408.0 сая.төгрөг, үйлдвэрлэлийн бус ажиллагаанд 4,613.2 сая. төгрөг, 50 МВт-ын төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал 617.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Нийт төлөвлөснөөс 3,595.1 сая төгрөгөөр өссөнд валютын ханшийн бодит бус алдагдал нөлөөлсөн бөгөөд валютын ханшийн бодит бус алдагдлыг тооцохгүйгээр нийт зардал 336.0 сая төгрөгөөр хэтэрсэн.

Үйл ажиллагааны зардлын бүтэц



Үйл ажиллагааны ашиг, алдагдал /сая.төг/



Ашиг, алдагдал: Компани 2022 оны батлагдсан төлөвлөгөөгөөр 6,391.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаас жилийн эцэст 4,979.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. “Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт шинэ станцаар өргөтгөх төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны орлого, зардлын тайланд нэгтгэж бүртгэснээр 5,470.7 сая төгрөгийн балансын алдагдалтай ажилласан.

Төлөвлөснөөс алдагдал буурахад нөлөөлсөн хүчин зүйлс:

- Илүү үйлдвэрлэл, түгээлтээс 2.0 тэрбум төгрөг.
- Үнэ тарифын өсөлтөөс 1.7 тэрбум төгрөгийн орлого тус тус олсон.

Өр төлбөр

сая.төг

д/д	Өр төлбөрийн төрөл	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт	
				Өмнөх оноос	Өмнөх оноос
1	Дансны өглөг	2,226.50	6,162.22	3,935.72	177%
2	Татварын өглөг	389.64	1,204.05	814.41	209%
3	Урьдчилж орсон орлого	150.08	400.17	250.09	167%
4	Цалингийн өглөг/төсөл/	119.71	198.34	78.63	66%
5	НДШ-ийн өглөг/төсөл	125.84	178.78	52.94	42%
6	Хүүгийн өглөг /МУ-ын хөгжлийн банк зээл/	268.65	472.57	203.92	76%
7	Богино хугацаат өрт төлбөр	3,280.42	8,616.13	5,335.71	163%
8	Урт хугацаат өр төлбөр	27,115.99	41,951.30	14,835.31	55%
9	Нийт өр төлбөр	30,396.40	50,567.43	20,171.03	66%

Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих “Чойбалсангийн ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт шинэ станцаар өргөтгөх” төслийн нийт санхүүжилт 79.49 сая ам.доллар ба үүний 60.0 сая ам.долларыг МУ-ын Хөгжлийн банкны зээлээр, 19.49 сая ам.долларыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр МУ-ын хөгжлийн банкнаас анхны 19,771.6 сая төгрөг, 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 11,968.05 сая төгрөгийн зээлийг авч гүйцэтгэгч компанид тус тус олгосон.






Авлага

сая.төг

д/д	Авлагын төрөл	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт	
				Өмнөх оноос	Өмнөх оноос
1	ЦДЭХ-ний авлага /ДБЭХС/	414.39	1,224.06	809.67	195%
2	ЦЭХ-ний авлага /Сүхбаатар/	40.23	47.65	7.42	18%
3	Төрөөс төлөх ЦДЭХ-ний авлага	1,268.34	-	(1,268.34)	-100%
4	Татвар, НДШ-ийн авлага	784.60	1,215.37	430.77	55%
5	Бусад авлага	314.90	295.37	(19.53)	-6%
6	Нийт авлага	2,822.46	2,782.45	(40.01)	162.5%

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар /сая.төг/



“ДБЭХС” ТӨХК-ийн 2022 оны жилийн санхүүгийн тайлан

ДБЭХС ТӨХК-ийн
2022 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн
Бодит байдлын тухай мэдэгдэл

2022 оны 12 сарын 31 өдөр

Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Ерөнхий нягтлан бодогч Д.Гэрэлчулуун бид манай аж ахуйн нэгжийн 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдөрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 17.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх амил гүйцээж бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх төлөвлөлт үнэн хийгдсэн.
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан.
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйцээжээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйцээжээс орхигдсон зүйл байхгүй.
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн тайланчлалын эсөн улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан.
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны амлалд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Гүйцэтгэх захирал

(Г.ОТГОНБААТАР)

Ерөнхий нягтлан бодогч

(Д.ГЭРЭЛЧУЛУУН)



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ДБЭХС ТӨХК

2022 оны 12 сарын 31 өдөр

/Аж ахуй нэгж, байгууллагын нэр/

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант үе	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1.00	ХӨРӨНГӨ	*	*
1.10	Эргэлтийн хөрөнгө	*	*
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	632,506,965.47	489,022,533.74
1.1.2	Дансны авлага	454,618,908.30	1,271,712,684.67
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	784,600,264.36	1,216,372,232.17
1.1.4	Бусад авлага	1,583,237,007.74	295,371,684.38
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,614,529,701.67	2,455,542,589.62
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/гооцро	6,015,158,040.00	11,393,150,383.85
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	184,843,000.00	185,552,000.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,279,533,887.54	17,305,724,273.44
1.20	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	94,813,319,760.35	108,493,427,400.37
1.2.2	Биет бус хөрөнгө	16,336,606,034.16	18,386,493,757.67
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	113,151,925,794.51	126,881,921,158.04
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	124,431,459,682.05	144,187,645,431.48
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.10	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,226,499,990.08	6,162,220,926.10
2.1.1.2	Цалингийн өглөг	119,710,156.86	198,336,278.52
2.1.1.3	Татварын өр	389,643,001.25	1,204,053,369.27
2.1.1.4	НДШ-ийн өглөг	125,837,601.89	176,790,306.33
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	256,649,432.58	472,572,686.75
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	150,078,877.65	400,165,476.39
2.1.1.9	Ноог /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамрагдах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,280,419,060.91	8,616,129,043.36
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	27,115,990,130.23	41,851,256,173.51

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Хойшлогдсон орлого	10,360,125,505.18	15,514,821,137.21
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	37,476,116,735.41	57,465,897,310.72
2.20	Өр төлбөрийн нийт дүн	40,766,535,796.32	66,082,016,354.08
2.30	Эздийн өмч		
2.3.1	Үнэ:		
2.3.2	- төрийн	50,825,827,452.43	51,370,219,512.43
2.3.3	- хувийн		
2.3.4	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,245,314,869.70	11,132,551,322.81
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,844,022,560.00	18,545,030,500.88
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,759,959,003.60	-2,942,172,258.62
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	83,674,923,885.73	78,105,629,077.40
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	124,431,459,682.05	144,187,645,431.48

Гүйцэтгэх захирал

(Г.ОТГОНБААТАР)

Ерөнхий нягтлан бодогч

(Д.ГЭРЭЛЧУЛУУН)



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ДБЭХС ТӨХК

/Аж ахуй нэгж, байгууллагын нэр/

2022 оны 12 сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	50,422,702,203.37	50,558,146,931.60
2	Борлуулалтын өртөг	36,179,438,405.42	38,589,849,108.66
3	Нийт ашиг/алдагдал	14,243,263,797.95	11,968,196,822.86
4	Түрээсийн орлого	31,838,270.15	60,997,054.57
5	Хүүний орлого	828,347.66	0.00
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,372,079,618.57	861,359,253.85
9	Борлуулалт, маркетингийн зардал	9,783,267,669.58	10,396,218,174.78
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,110,462,608.87	2,331,838,500.58
11	Санхүүгийн зардал	78,853,776.98	73,690,521.15
12	Бусад зардал	2,882,973,803.96	2,157,834,128.21
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-58,700,795.15	-3,391,876,046.61
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	734,561,458.01	-5,470,702,241.26
19	Орлогын татварын зардал	46,176,322.52	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	688,385,135.49	-5,470,702,241.26
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-
22	Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	688,385,135.49	-5,470,702,241.26
23	Бусад дэлгэрэнгүй орлого		-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
23.3	Бусад олз (гарз)		-
24	Орлогын нийт дүн	688,385,135.49	-5,470,702,241.26
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг/алдагдал		

Гүйцэтгэх захирал

(Г.ОТГОНБААТАР)

Ерөнхий нягтлан бодогч

(Д.ГЭРЭЛЧУЛУУН)

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 сарын 31 өдөр

ДБХС ТӨХ

(Аж ахуй нэгж, байгууллагын нэр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халамны хувьцаа	Нэмж тогтоосон хэмжээ	Хөрөнгийн дахин уналттай нэмэгдэл	Гадаад валютын хөрөнгийг далгүйн нэмэгдэл	Эзлэг өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	48,102,825,728.66	0.00	0.00	11,295,907,288.04	0.00	21,022,232,225.77	2,054,190,188.96	82,475,155,429.46
2	Нөхцөл бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлийн нөлөө алдааны залруулга							12,156,169.16	12,156,169.16
3	Залруулсан үлдэгдэл							2,063,340,358.17	92,407,313,578.64
4	Тайлант үеийн цэвэр ашиг (адагдал)							988,385,135.49	988,385,135.49
5	Бусад дэлгэрэнгүй орлого								0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	2,722,801,725.77					-2,178,203,665.77	-45,388,888.40	544,592,050.00
7	Зарласан нэгдөл ашиг							50,592,398.34	-45,388,888.40
8	Дахин уналттай нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-50,592,398.34				0.00
9	2021 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	50,825,627,452.43	0.00	0.00	11,245,314,859.70	0.00	18,844,022,560.00	2,759,959,003.50	93,674,923,885.73
10	Нөхцөл бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлийн нөлөө алдааны залруулга								0.00
11	Залруулсан үлдэгдэл								0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (адагдал)							-6,470,702,241.28	-6,470,702,241.28
13	Бусад дэлгэрэнгүй орлого								0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	544,592,050.00					-298,892,059.32		245,699,990.68
15	Зарласан нэгдөл ашиг							-344,192,587.75	-344,192,587.75
16	Дахин уналттай нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-112,763,546.79			112,763,546.79	0.00
17	2022 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	51,370,219,512.43	0.00	0.00	11,132,551,322.91	0.00	18,545,030,500.68	-2,842,172,258.62	78,105,828,077.40

Гүйцэтгэх захирал (Г.ОЛОНБААТАР)

Брөхийн Агтлаагч (Д.ГЭРЭЭНУУН)



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ДБЗХС ТӨХК

2022 оны 12 сарын 31 өдөр

/Аж ахуй нэгж, байгууллагын нэр/

/Тогтворлоо/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12 сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн зарлагын дүн (+)	49,169,630,695.60	55,763,637,501.02
1.1.1	Баривчлол, үйлчилгээ үзүүлсний орлого	48,137,670,134.35	54,601,641,117.15
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, тэтгэврийн орлого		
1.1.3	Далтгалын нэхлээрээс хүлээн авсан мөнгө	46,569,378.00	88,342,649.00
1.1.4	Буцаан авсан албан тэтгэвэр		
1.1.5	Татвар, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	985,381,183.25	1,083,653,434.67
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	43,357,174,984.77	47,962,804,957.67
1.2.1	Ажилчдад төлсөн	12,090,519,268.84	14,114,528,750.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,728,776,064.29	4,343,026,506.12
1.2.3	Баривчлол худалдан авахад төлсөн	13,223,798,987.30	11,293,319,107.55
1.2.4	Ажиллагсийн зардалд төлсөн	41,106,362.07	35,751,283.36
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,476,351,090.05	12,135,584,590.75
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	78,853,770.98	2,083,948,207.55
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,080,270,819.15	3,472,450,768.60
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	84,714,710.06	179,723,503.75
1.2.9	Бусад мөнгөн зарлага	642,975,170.21	414,470,438.46
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,812,455,710.83	7,790,832,543.35
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,468,847.88	5,460,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	4,670,600.00	5,450,000.00
2.1.2	Бичиг бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан зүүний орлого	829,347.88	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	24,136,789,875.94	19,434,327,270.76
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	4,426,150,504.70	7,424,197,236.05
2.2.2	Бичиг бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	8,950,000.00	42,085,363.64
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	19,724,688,371.24	11,968,053,671.07
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	-
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-24,133,290,028.06	-19,428,877,270.76
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	19,724,688,388.81	11,968,053,671.07
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаар хүлээн авсан	19,724,688,371.24	11,968,053,671.07
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаар хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандил	-	-
3.1.4	Валютын ханшийн өсөлт	17.37	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	834,766,568.52	503,493,370.39
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	788,618,286.22	135,798,074.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн аялалт төлсөн	22,781,384.60	23,604,728.84
3.2.3	Хувьцаа буцаан авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	45,366,888.40	344,182,557.75
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	18,889,921,820.09	11,464,560,300.68
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	569,087,502.86	-173,484,428.73
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	93,419,462.61	562,506,965.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	562,506,965.47	489,022,638.74

Гүйцэтгэх захирал

(Г.ОТГОНБААТАР)

Ерөнхий нэгжлэн бодлогч

(Д.ГЭРЭЛЧУЛУУН)

“ДБЭХС” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ

№	ҮЗҮҮЛЭЛТ	ШИНЖИЛГЭЭНИЙ ТОМЪЁО	2021 он		2022 он		Тайлбар
1.1	Борлуулалтын ашигт ажиллагаа	Нийт ашиг	14,243.26	28%	11,968.20	24%	Борлуулалтаас тооцсон нэмэгдлийн хувь (их байвал сайн)
		Борлуулалтын орлого	50,422.70		50,558.15		
1.2	Өртгөөр тооцсон ашигт ажиллагаа	Нийт ашиг	14,243.26	39%	11,968.20	31%	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгөөс тооцсон нэмэгдлийн хувь (их байвал сайн)
		ББӨртөг	36,179.44		38,589.95		
1.3	Хөрөнгийн ашигт ажиллагаа	Цэвэр ашиг	688.39	0.6%	-5,470.70	-3.8%	Тухайн компанийн балансын хөрөнгийн ашигт ажиллагааны түвшинг харуулна (их байвал сайн)
		Балансын дүн	124,431.46		144,187.65		
1.4	Өөрийн капиталын ашигт ажиллагаа	Цэвэр ашиг	688.39	0.8%	-5,470.70	-7.0%	Компаний өөрийн цэвэр хөрөнгө оруулалтын ашигт ажиллагааны түвшинг харуулна (их байвал сайн)
		Өөрийн капитал	83,674.92		78,105.63		
2. Төлбөрийн чадварын шинжилгээ							
2.1	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	Мөнгөн хөрөнгө	662.51	20%	489.02	6%	Бэлэн мөнгөөр өр төлбөрийнхөө хэдэн хувийг барагдуулж чадах (их байвал сайн)
		Богино хугацаат өр төлбөр	3,280.42		8,616.13		
2.2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	Мөнгөн хөрөнгө+Авлага	2,822.46	0.86	3,271.48	0.38	Авлагаа цуглуулаад өр төлбөрийнхөө хэд дахин төлж чадах чадварыг харуулна. (их байвал маш сайн)
		Богино хугацаат өр төлбөр	3,280.42		8,616.13		
2.3	Эргэлтийн харьцаа	Нийт эргэлтийн хөрөнгө	11,279.53	3.44	17,305.72	2.01	Нийт эрэгэлтийн хөрөнгөөрөө өр төлбөрөө хэд дахин төлж чадах чадварыг харуулна. (1.5-аас их байвал маш сайн)
		Богино хугацаат өр төлбө р	3,280.42		8,616.13		
2.4	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	Нийт эргэлтийн хөрөнгө	11,279.53	9%	17,305.72	12%	Нийт хөрөнгийн үр ашигтай ашиглалтыг харуулсан үзүүлэлт их байх тусмаа сайн.
		Балансын цэвэр дүн	124,431.46		144,187.65		
3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ							
3.1	Бие даах чадварын коэффициент	Өөрийн хөрөнгө	83,674.92	67%	78,105.63	54%	Балансанд өөрийн хөрөнгийн эзлэх хувийг харуулна. 50 хувиас их байлгах
		Балансын цэвэр дүн	124,431.46		144,187.65		
3.2	Гадны хөрөнгийн хувийн жин	Гадны хөрөнгө	40,756.54	33%	66,082.02	46%	Балансанд гадны хөрөнгийн эзлэх хувийг харуулна. 50 хувиас бага байлгах
		Балансын цэвэр дүн	124,431.46		144,187.65		
3.3	Гадны ба өөрийн хөрөнгийн харьцаа	Гадны хөрөнгө	40,756.54	49%	66,082.02	85%	Гадны хөрөнгө болон өөрийн хөрөнгө харьцаа 100 хувиас ихгүй байх
		Өөрийн хөрөнгө	83,674.92		78,105.63		
4. Эргэцийн шинжилгээ							
4.1	Авлага цуглуулах дундаж хугацаа	Авлага*360хоног	163,662.81	3.25	457,816.56	9.06	"Дансны авлага үүсч бий болоод төлөгдөж орж ирэх хүртэлх хугацаа
		Борлуулалтын орлого	50,422.70		50,558.15		
4.2	Төлбөр төлөх дундаж хугацаа	Дансны өр*360 хоног	801,540.00	35.31	2,218,399.53	95.05	Дансны өрөө дунджаар хэд хоногт барагдуулж байгааг харуулна. Бага байвал сайн.
		Худалдан авалт	22,700.15		23,338.90		
4.3	Бараа материалын эргэц	ББӨ	36,179.44	22.41	38,589.95	15.72	Бараа материалын дундаж наслалтыг харуулна.
		Бараа материалын нөөц	1,614.53		2,455.54		
5. Бүтээмжийн шинжилгээ							
5.1	"Борлуулалтын ашигт ажиллагаа"	Цэвэр ашиг	688.39	1.4%	-5,470.70	-10.8%	"1 төгрөгийн борлуулалтын орлогоос олж байгаа ашгийн түвшинг илэрхийлнэ."
		Борлуулалтын орлого	50,422.70		50,558.15		
5.2	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	Борлуулалтын орлого	50,422.70	139.4%	50,558.15	131.0%	Ахиуц нийт ашиг нь өндөр байвал ББӨ бага, бага байвал ББӨ өндөр байгааг илэрхийлдэг.
		ББӨртөг	36,179.44		38,589.95		
5.3	"Хөрөнгийн ашигт ажиллагаа"	Цэвэр ашиг	688.39	0.6%	-5,470.70	-3.8%	"Эздийн өмчийн 1 төгрөг тутамд ногдож буй цэвэр ашгийн хэмжээ буюу өмчийг хэрхэн үр ашигтай ашиглаж байгааг илэрхийлнэ."
		Нийт хөрөнгө	124,431.46		144,187.65		
5.4	"Өөрийн капиталын ашигт ажиллагаа"	Цэвэр ашиг	688.39	0.8%	-5,470.70	-7.0%	
		Өөрийн капитал	83,674.92		78,105.63		



Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд

Компанийн дотоод журам, Захиргаа, үйлдвэрчний хорооны хооронд байгуулсан 2022 оны хамтын гэрээний дагуу ажилтан болон өндөр настан, ахмадуудад буцалтгүй тусламж, хөнгөлөлт, нэмэгдэл, урамшууллыг олгож ажилласан.

2022 онд компанийн дотоод журам, хамтын гэрээнд заасан нийт 10 төрлийн хөнгөлөлт, тэтгэмж, дэмжлэг, тусламжид давхардсан тоогоор 1546 ажилтанд 1,112.7 сая төгрөгийг зарцуулсан.

д/д	Зардлын төрөл	2022 он	
		Хамрагдсан ажилтны тоо	Зарцуулсан дүн /сая.төг/
1	Ажилтнуудын хоолны хөнгөлөлт	620	537,2
2	Ажилтнуудын түлшний хөнгөлөлт	83	8,0
3	Ажилтнуудын унааны хөнгөлөлт		11,2
4	Ажилтанд олгосон тусламж, буцалтгүй тусламж	36	58,0
5	Тэтгэмж	12	292,5
6	Нөхөн олговор	1	19,4
7	Эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ, сувилгааны зардал	620	49,7
8	Ажилтнуудад олгосон шагнал урамшуулал	83	89,6
9	Болзолт уралдаан	60	29,5
10	Урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээний зардал	31	17,6
	ДҮН	1,546	1,112,7

2022 оны цалин хөлсний талаар

Эрчим хүчний сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07 ны өдрийн а/20 тоот тушаалаар компанийн ажилтнуудын үндсэн цалинг 2022 оны 01 дүгээр сарын 01нээс 100,000 төгрөгөөр буюу дундажаар 10.6 хувиар нэмэгдүүлсэн.

Цалин хөлсний бүрэлдэхүүн

- Үндсэн цалин 45.7%
- Сарын үр дүнгийн шагнал 16.8%
- Жилийн үр дүнгийн шагнал 14.9%
- Удаан жил нэмэгдэл 11.3%
- Илүү цагийн нэмэгдэл хөлс 3.7%
- Шөнийн цагийн нэмэгдэл хөлс 5.8%
- Бусад нэмэгдлүүд 1.8% тус тус эзэлдэг.

Дундаж цалин хөлс, өсөлтийн судалгаа /төг/



Компанийн хэмжээнд дундаж цалин хөлс 1,970.5 мянган төгрөг болж өмнөх оноос 13.9%-аар буюу 240.5 мянган төгрөгөөр өссөн.

Компанийн нийт зардалд цалингийн зардал эзлэх хувь





4

БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТ

Худалдан авах ажиллагааны талаар

“ДБЭХС” ТӨХК нь 2022 оны жилийн эцсийн байдлаар өөрийн хөрөнгөөр нийт 10,889.0 сая төгрөгийн 96 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. 2022 онд ковид-19 цар тахалтай холбоотойгоор тухайн жил тэвчиж болох зардлуудаа танах чиглэлийн дагуу нийт 604,990 мянган төгрөгийн 6 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг цуцалсан. Дээрх 10,860.7 сая төгрөгийн худалдан авалтыг хассан дүнгээр 10,564.8 сая төгрөгийн 91 худалдан авалт зохион байгуулж худалдан авах ажиллагааны биелэлт 99 хувь байна.

Худалдан авах арга



Гүйцэтгэл /сая.төг/



2023 онд дуусах ажлууд:

Горим ажиллагаанаас хамаарч ажлын материалыг хүлээн авч хугацаа сунгагдсан.

- Зуух №6-ын уур халаагчийн 1,2 дугаар үе солих ажил
- Зуух №6-ын нүүрсний бункер солих ажил
- Зуухны хяналт удирдлагын системийн шинэчлэлийн ажил

Бүтэн жилийн гэрээтэй. Хугацаа 2023 оны 04 сард дуусах

- Барилгын материал нийлүүлэх
- Цахилгааны материал нийлүүлэх
- Шатахуун, дизель түлш, шатах тослох материал
- Принтерийн хор нийлүүлэх
- Даатгалын үйлчилгээ

№	Дотоодын үйлдвэрээс авсан бараа		Дүн /сая.төг
1	Хөдөлмөр хамгааллын хувцас	Бараа	96,7
2	Витаминжуулалт	Бараа	3,1
3	Хор саармагжуулах сүү	Бараа	13,9
4	Хөвөнтэй бээлий	Бараа	3,9
5	Мяндсан шүүр	Бараа	16,6
6	ММТ-1300/1332/735, S16 маркийн алхан тээрмийн алх	Бараа	221,1
7	Давс	Бараа	109,0
	Нийт		464,3



5

ТЕХНОЛОГИЙН САХИЛГА

Өвлийн бэлтгэл ажлын биелэлт /100%/

2022-2023 оны өвлийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийт 51 багц ажил төлөвлөж, 2022 оны 12 дугаар сард төлөвлөгдсөн ажлууд бүрэн хийгдэж дууссан. 2023 оны 1 дүгээр сарын байдлаар:

- Аваарын ПАЭС станцын түлш 10.8 тн
- Технологийн хэрэгцээний давс 74.0 тн
- Талбайн нүүрсний нөөц 21232 тн / 11 хоног/
- Мазутын нөөц 226,0 тн тус тус нөөцтэй.

Үндсэн тоноглол

2022 онд Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөний дагуу зуух №2, турбогенератор №4 д их засварын ажлууд хийгдсэн.

Үндсэн тоноглолын ажилласан хугацааг харьцуулахад /цагаар/

Д/д	Үндсэн тоноглолууд	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Зуух №1	7551	7344	6430	7264
2	Зуух №2	7169	7145	7340	5661
3	Зуух №3	7419	5795	7374	7454
4	Зуух №4	7846	7246	6733	7472
5	Зуух №5	6063	6724	7577	6950
6	Зуух №6	7691	7444	8039	7592
7	Турбогенератор №1	8504	8733	8332	8624
8	Турбогенератор №2	8126	8579	8727	8752
9	Турбогенератор №3	8726	7921	8640	8284
10	Турбогенератор №4	8652	8472	8721	7489

Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ний ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл

Компанийн 2022 оны хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хийгдэх ажил болон их засварын ажлын төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн а/123 тоот тушаалаар 7,049.8 сая төгрөгийн 48 нэр төрөл бүхий ажил хийхээр тодотгон баталсан.

Тайлант онд их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэлээр /гэрээний дүнгээр/ 5,938.15 сая төгрөг буюу 93.75% гарсан байна.



Хөрөнгө оруулалт: Нийт 25 багц худалдан авалт хийгдэж гүйцэтгэл 100% -тай байна.

ТЗБАХ: Нийт 11 багц ажил хийгдэж гүйцэтгэл 97% байна. Зуухны хяналт удирдлагын системийн шинэчлэл хийх ажлын гүйцэтгэлийг 80% иар аасан.

Их засвар: Нийт 12 багц ажил хийгдэж гүйцэтгэл 95% байна. Зуух №-6 уур халаагч 1,2 дугаар үе солих ажил, Зуух №6 нүүрсний бункер солих, Өндөр даралтын халаагч №3А, 4А зүрхэвч солих ажлууд 80%-ийн материалын гүйцэтгэлтэй байна.

Засварын төрөл	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт хувиар
	Нэр төрөл (тоо)	Дүн (мян.төг)	Нэр төрөл (тоо)	Дүн (мян.төг)	Нэр төрөл (тоо)
Их засвар	12	2,008.48	9	1,564.80	95%
Хөрөнгө оруулалт	25	2,720.81	25	2,562.21	100%
ТЗБАХ	11	2,320.47	11	1,811.14	97%
ДҮН	48	7,049.8	45	5,938.15	93.75%

ТЗБАХ, Их засварын шалтгаан: “Зуухны хяналт удирдлагын системийн шинэчлэлийн” материал нийлүүлэх хугацааг үйлдвэрлэгч хил гаалийн асуудалтай холбоотойгоор Honeywell ExPerion системийн С300 техник хангамжийн эд ангиудад ашиглагдах чипийн хомсдол үүсэж 2022 оны 12 дугаар сард, “МЭЗ”ХХК ийн уур халаагчийн материал нь хил гааль бараа материал нэвтрүүлэхгүйтэй холбоотойгоор 2022 оны 10 дугаар сард тус тус материал нийлүүлэгдэж эхэлсэн. Өвлийн их ачаалал эхэлснээр үндсэн тоноглол зогсоох боломжгүй болсон тул дээрх 2 ажлын гүйцэтгэлийг материал нийлүүлэгдсэнээр хаасан.



2022 онд хийгдсэн томоохон ажлуудаас:

Зуух №2 ийн халах гадаргуугийн их засвар.



Турбогенератор №4-ийн их засварын ажил бүрэн хийгдэж засварын дараах турбины роторын динамик баланс хийж, балансын I хавтгай – роторын сүүлийн үеийн диск, II хавтгай – 1 үеийн диск байхаар байрлуулсан.



Үлээх салхилуур №1 давтамж хувиргуур суурилуулах, хөдөлгүүр шинэчлэх

Уг шинэчлэлийн ажлын хүрээнд цахилгаан хөдөлгүүрийг олон улсын стандартын шаардлагад нийцсэн IE-2 стандартын ашигт үйлийн коэффициент өндөртэй ВРУ-315L1-6 загварын 110 кВт чадалтай албадмал хөргүүрийн сэнстэй хөдөлгүүрээр шинэчилж, АВВ-ийн ACS580-01-246А-4, IP55 хамгаалалтын зэрэгтэй давтамж хувиргуур суурилуулсан. Мөн шинэчлэлийн ажлын хүрээнд хөдөлгүүрийн тэжээлийн кабель, удирдлагын хэлхээний кабелиуд, тэдгээрийн трассыг бүрэн шинэчилж найдвартай ажиллагааг сайжруулсан.

Гарсан үр дүн :

- Ерөнхий агаарын шибенийн байрлал ажиллагааны явцад 10-40% нээлттэй явдаг. Давтамж хувиргуур суурилуулсанаар ерөнхий агаарын шиберыг 89% нээж, эргэлтийн хурдыг 400 хүртэл бууруулсан.

ДВ-1 ийн өмнөх цахилгаан эрчим хүч зарцуулалт 47 кВт.цаг байсан бөгөөд давтамж хувиргуур суурилуулсанаар 16-20 кВт.цаг болж буурсан.



Засварын ажлын талаар:

ДБЭХС ТӨХК нь 2020-2021 оны өвлийн бэлтгэл хангаж хийх ажлын хүрээнд хийгдэх ӨДХ-ийн бүрэн зогсолтын засварын ажил амжилттай хийгдлээ. ДДС-ын бүрэн зогсолтын ажил төлөвлөгөөний дагуу 100%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж дууссан.



Конденсаторын гуулин хоолой

2022 оны хөрөнгө оруулалтаар Турбогенератор №3,4-ийн конденсаторын гуулин хоолойг сольсноор машины уурын хувийн зарцуулалт буурч 11,749.8 тн нүүрс хэмнэж, 229.1 сая төгрөгийн үр ашигтай гарч, 8,825.1 тн CO₂ агаар мандалд ялгаруулахыг бууруулсан.



Турбины тохируулгын блокийг төлөвлөгөөт зогсолтоор турбогенератор №4 2022 оны 09 дүгээр сарын 28 ны өдөр шинээр монтажлан угсрав.



Эрчим хүч хэмнэлт

“ДБЭХС” ТӨХК нь 2022 онд эрчим хүч хэмнэлтийн ажилд 722.4 сая төгрөгийн 5 ком ажил төлөвлөгөөний дагуу хийгдсэн.

Төлөвлөгөөт нийт 5 ажлаар 122,638 кВт.цаг, 249.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 9036 тн CO₂ хүлэмжийн хийг агаар мандалд ялгаруулахыг бууруулж, дэлхийн дулаарлын эсрэг хувь нэмрээ оруулсан.

Компанийн цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах усны хэмжээг нарийвчлан хэмжиж тоолууржуулсанаар 55.0 сая төгрөгийн зардлын хэмнэлт гаргаж ажилласан.

Ухаалаг тоолуур

2022 онд гэр хорооллын дэд станц КТП-85-ын нийт 78 тоолуурын самбарт 315 хэрэглэгчийн тоолуурыг DDZY88 маркийн нэг фазын ухаалаг тоолуураар шинэчлэн солих ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хүрсэн үр дүн:

- Цахилгаан эрчим хүчний балансжилд илүү оновчтой болж, тухайн дэд станцын техникийн алдагдлыг илүү нарийвчлалтай тооцох мөн арилжааны алдагдлыг бууруулах нөхцөл боломж бүрдсэн.
- КТП-85 дэд станцын алдагдал биетээр 2.3 мян.кВт.цаг буюу /0.46%/ буурсан.
- Дэд станцуудын тоолуурын заалт авах ажил 2 хоногийн хугацаа, бичилт хийх ажилд 5-н цаг зарцуулдаг байсан бол ухаалаг болсноор заалт татаж, бичилт уншуулах ажилд нийт 8 минут зарцуулж байна.

Таслалт, залгалт хийх ажлууд бүрэн автомат хэлбэрт шилжсэн.



- Гэмтэл дуудлагын тоо тэг болж буурсан. Иймээс дээрх ажлуудыг хийхэд ажилчдын оролцоо багассан, цаг хугацаа алдахгүй түргэн шуурхай болсон, хөдөлмөрийн цаг хугацааг хэмнэж, аваар осолгүй ажиллах нөхцөл боломж бүрдсэн.

Үйлдвэрлэлийн осол аваар, саатал

2022 онд компанийн хэмжээнд аваар осолгүй ажилласан ба I, II зэргийн саатал гараагүй.

Саатлын зэрэг	2019 он	2020 он	2021 он	2022 он
Аваарь	0	0	0	0
1-р зэргийн саатал	0	1	0	0
2-р зэргийн саатал	0	1	0	0

Сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн хэмжээ өссөн ч аваар гараагүй нь ажилтнуудын техникийн сахилга хариуцлага сайжирсан, тоноглолуудын ашиглалт, засварын түвшин дээшилсэн, үндсэн тоноглолуудын горимын сонголт эрсдэл багатай, оновчтой байсан зэргээс шалтгаалсан байна.



Ашиглалтын жигд ажиллагаа, горимын зөрчил

Үндсэн тоноглолын зогсолт

2022 онд өвлийн их ачааллын хугацаанд зуны засварын улиралд ажиллах үндсэн тоноглолуудын графикийг үйлдвэрлэлийн төлөвлөгөө, цахилгаан ачааллын таац, үндсэн тоноглолын засварын ажил, бүс нутгийн цаг агаарын урьдчилсан төлөв зэргийг үндэслэн төлөвлөж, мөрдүүлэн горим төлөвлөлт 100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.

2022 онд үндсэн тоноглол болох зуухны горим төлөвлөлтийг нарийвчилж, засварын ажлын чанар сайжирснаар графикт бус зогсолтын тоо 5-аар буурсан.

Үндсэн тоноглолын зогсолтын харьцуулалт:

Үндсэн тоноглолын зогсолтууд	2020 он		2021 он		2022 он	
	Графикт	Графикт бус	Графикт	Графикт бус	Графикт	Графикт бус
Зуух	18	6	22	3	19	0
Турбин	8	4	7	6	9	4
НИЙТ	26	10	29	9	28	4

Үндсэн тоноглолын төлөвлөгөөт бус зогсолтууд

Д/д	Зөрчлийн шалтгаан	Дутуу түгээсэн цахилгаан эрчим хүч /кВт.цаг/	Гарсан огноо	Цех
1	ТГ-4 Роторын ороомгийн 2 р ороомгийн 1 р ороодос тасарсан.		I/14	Цахилгаан цех
2	ТГ-1 Б/У 110 кВ АШ залгасны дараа 1Т/2Т сэлгэн залгалт хийх үед дифф хамгаалалт ажилласан.		VI/17	Цахилгаан
3	Турбогенератор №4 ийн их биеийн суганы жийрэг сэтэрсэн.		III/17	ТХЦ
4	ТГ-4 д ОРУ-6/35 кВ 2Т трансформаторыг ажилд залгаж, 1Т трансформаторыг таслах сэлгэн залгалт хийгдсэн. Сэлгэн залгалтын өмнө СВВ-17 таслуур залгаж, кольцо схемд оруулж, ТГ-1,2,3,4 дифференциаль хамгаалалтууд ажлаас гаргав. 2Т трансформаторын сэлгэн залгалтыг хийх үед балансын биш гүйдэл үүсэж 0.17 сек үргэлжилж, дифференциаль хамгаалалт ажилласан.	18864	XII/16	Цахилгаан

Эрчим хүчний хязгаарлалт, дутуу түгээлт

2022 онд системийн хэмжээнд үндсэн тоноглолын зогсолт, гэмтэл саатал, тоноглолууд хэт ачаалагдсан, ЦШС-ний шугам тоноглолын гэмтэл зэргээс шалтгаалсан нийт 24.1 мян.кВт.цаг ЦЭХ дутуу түгээсэн.

6

ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ

Үйл ажиллагааны хамрах хүрээ,

Дорнод болон Сүхбаатар аймгийн төв болон 36 баг суурин газар цахилгаан эрчим хүчээр холбогдсон байна.



Нийт хэрэглэгчид
33,252



Уул уурхай
17



Ахуйн
хэрэглэгчид
30,390



Төсвийн
хэрэглэгчид
337



Бусад
ҮААНБ
2,474




Импортын
хэрэглэгчид
34



ЦЭХ-ний хэрэглэгчийн тоо сүүлийн таван жилийн харьцуулалт


Ангилал	Он				
	2018	2019	2020	2021	2022
Уул уурхай	15	17	17	17	17
ААН байгууллага	2,161	2,357	2,516	2,702	2,845
Орон сууц	7,217	7,621	8,232	8,262	9,668
Гэр хороолол	19,129	20,074	20,496	20,780	20,722
Нийт	28,522	30,069	31,261	31,761	33,252

2022 оны ЦЭХ-ний хэрэглээний бүтэц



Цахилгаан эрчим хүч түгээлт, борлуулалт

2022 оны ЦЭХ-ний алдагдлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.кВт.ц/



2022 оны ЦЭХ-ний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.кВт.ц/



ЦЭХ-ний борлуулалтын, үзүүлэлт /сая.кВт.ц/





Цахилгаан эрчим хүчний алдагдал

Алдагдал /%/



Цахилгаан эрчим хүчний шугамын алдагдал өсөж гарсан шалтгаан нь Өндөрхаан-Баруун-Урт 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам хүчдэлийн уналт ихтэй ажиллагаанд явсан (зарим тохиолдолд 96 кВ) нь нөлөөлсөн.

Дорнод аймгийн хэмжээнд Чойбалсан 110/35/6кВ-ын дэд станцаас Сүхбаатар 110кВ-ын ЦДАШ-ыг сэлгэн залгалтаар тэжээхэд үүсэх шугамын алдагдал 194.799 мян.кВт.ц гарсан.

Чойбалсан 110/35/6кВ-ын дэд станцын 2Т-16000кВА, 3Т-1000кВА чадалтай трансформатор, ТЭЦ-ийн 2Т-16000кВА чадалтай трансформаторуудын алдагдал 412.0 мян.кВт.ц, ХХЕМ-ийн 3Т-16000кВА трансформаторын алдагдал 995.4 мян. кВт.ц гарсан нь нийт техникийн алдагдлын 11.19%-ийг эзлэж байна.

Дорнод аймгийн сумдын хэмжээнд Дашбалбар сум хүчдэлийн уналтаас хамаарч жилд 274.6 мян.кВт.ц алдагдалтай гарсан бөгөөд бүх 10/0.4кВ-ын дэд станцуудын трансформаторуудын анцафта дээд тавилдаа тулсан горимд ажилласан. Халхгол сумын техникийн алдагдал 464.9 мян.кВт.ц, Баяндун, Баян-уул сумын техникийн алдагдал 457.6 мян.кВт.ц алдагдалтай гарсан нь тус сумдын цахилгаан ачаалал ихэссэнтэй холбоотойгоор техникийн алдагдал нэмэгдсэн.

Дулааны эрчим хүчний төвлөрсөн хангамжийн системд холбогдсон хэрэглэгчийн тоо өмнөх оноос 370 айл өрх, 2 аж ахуй нэгжээр нэмэгдсэн.

Он		2018	2019	2020	2021	2022
Айл өрх		6238	6481	6795	7056	7426
Аж ахуй нэгж байгууллага	Задгай	660	665	660	696	683
	Тоолууртай	176	185	176	202	204
Нийт		7055	7317	7645	7954	8313

ДЭХ-ний борлуулалтын орлого /сая.төг



ДЭХ-ний түгээлт/ мгДж





Орлогын хувь



Борлуулалтын орлого төвлөрүүлэлт ба авлага

2022 онд давхардсан тоогоор 345,280 хэрэглэгчид 55,874.65 сая төгрөгийн бичилт хийгдсэнээс 309,521 хэрэглэгчийн 55,078.69 сая төгрөгийн орлого цуглуулж гүйцэтгэл 98.5%-тай байна.

Орлогын хувь буурсан саруудад “Дорнод НАА” ОНӨААТҮГ, Чойбалсан хөгжил ХХК болон “Петро чайна дачин тамсан” ХХК, “Эм Эл Цахиурт овоо” ХХК, “Цайрт минерал” ХХК, “ХХЕМ” ХХК, мөн Хилийн цэргийн ангиуд зэрэг томоохон хэрэглэгчдийн төсөв болон барьцаа төлбөрөөс хэтэрсэн хэрэглээ гарч авлага үүсгэсэнтэй холбоотой.

Авлага

2022 оны 12 дугаар сард 7,974.63 сая төгрөгийн бичилт хийгдэж 8,136.90 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн 102 %-ийн гүйцэтгэлтэй. Оны эцэст 1,286.28 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй үлдсэн.

Эхний үлдэгдэл /сая.төг/	Бичилт /сая.төг/	Орлого /сая.төг/	Эцсийн үлдэгдэл /сая.төг/
1,406.18	7,974.63	8,136.90	1,286.28

Нийт авлагыг хэрэглэгчээр нь ангилбал:

Ангилал	Мөнгөн дүн /сая.төг/	Эзлэх хувь /%/
Үйлдвэр ААНБ	188.00	15
ААНБ	555.74	43
Ахуйн хэрэглэгч	501.06	39
Төсөв	25.61	2
Бусад	15.87	1

Авлага /Тэрбум.төг/




Насжилт:

2022 оны 2, 10 дугаар саруудад хуримтлагдсан их өр авлагыг бууруулах төлөвлөгөө батлуулж түүнийг хэрэгжүүлж ажилласан.


№	Насжилт	Мөнгөн дүн /сая,төг/	Нийт авлагад эзлэх хувь
1	Тайлант сар	1,123.83	87.37
2	30-90 хоног хугацаа хэтэрсэн	78.52	6.1
3	3-6 сар хугацаа хэтэрсэн	17.12	1.33
4	6-12 сар хугацаа хэтэрсэн	5.11	0.40
5	1-3 жил хугацаа хэтэрсэн	9.25	0.72
6	3 жилээс дээш хугацаа хэтэрсэн	52.45	4.08
7	Нийт дүн	1,286.28	100



Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед хэрэглэгчдийг цахилгаан дулааны эрчим хүчээр найдвартай хангах, Монгол улсын Засгийн газрын 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажилласан.



Гэр хорооллын тарифын хөнгөлөлт



Хэрэглэгчийн өргөдөл, гомдол

Өргөдөл гомдол хүсэлт нь нэг талаас ажлаа сайжруулах боломж, нөгөө талаас компанийн үйл ажиллагааны алдаа дутагдлыг харуулж өгдөг зүйл юм. Цахилгаантай холбогдолтой 371 өргөдөл ирсэн бөгөөд иргэнээс 287, ААНБ-с 84 өргөдөл ирж, өргөдөл гомдол барагдуулах журмын дагуу холбогдох цех хэсэг хэлтэст хуваарилж, хугацаанд нь гүйцэтгэлийг нь оруулж ажилласан.

№	Өргөдлийн хамрагдах төрөл	Дорнод салбар	Сүхбаатар салбар	Нийт өргөдөл	Шийдвэрлэсэн өргөдөл	Шийдвэрлэлтийн хувь
1	Цахилгаан - Хангамж, хэрэглээ	154	1	155	155	100%
	Цахилгаан - Төлбөр, тооцоо	55	122	177	177	100%
	Цахилгаан - Хэмжих хэрэгсэл	9	8	17	17	100%
	Цахилгаан - Бусад	10	12	22	22	100%
	Нийт	228	143	364	371	100%

Борлуулалт маркетингийн үйл ажиллагаа

Хэрэглэгч, олон нийтэд компанийн үйл ажиллагааны талаар зөв мэдээ мэдээлэл, хандлагыг бий болгох, эрчим хүчний үнэ цэнэ, зүй зохистой, ухаалаг хэрэглээг сурталчлан таниулж хүргэх чиглэлээр 2022 онд дараах ажлуудыг хийсэн.

Тайлант онд хэрэглэгчийн аян:

2022.01.04-наас 2022.02.21 хүртэлх хугацаанд Эрчим хүчний зохицуулах хороо болон Дорнод аймгийн зохицуулах зөвлөлтэй хамтран “ХЭРЭГЛЭГЧИЙН АЯН-2022” аяныг зохион байгуулсан.

Монгол улсын засгийн газрын 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн 410 тогтоолын талаар хэрэглэгчдэд “МЭДЭЭЛЭЛ” зурагт хуудас бэлтгэж “Хэрэглэгчдэд үйлчлэх төв -Дорнод салбар” facebook, “Хэрэглэгчдэд үйлчлэх төв -ДБЭХС ТӨХК” page цахим хаягуудаар мэдэгдсэн. Мөн орон нутгийн ТВ6, Дорнод ТВ, МИЖИ ТВ-ээр 7 хоногийн турш 2 цагийн давталттайгаар 147 удаа зар мэдээ явуулсан.





Цаг үеийн нөхцөл байдалд тохирсон өдөрлөгийн арга хэмжээнд оролцож иргэдэд нээлттэй мэдээлэл хүргэж ажилласан.

- 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдөр, 9 дүгээр сарын 22 ны өдөрлөгөөр 270 орчим хэрэглэгчдэд emongolia.mn-нэгдэж, цахимаар өргөдөл гомдол, цахилгаан дулааны техникийн нөхцөлийн хүсэлт хүлээн авч байгаа талаар мэдээлэл өгч ажилласан. Мөн цахилгаан, дулааны үнэ тариф, гэрээ, шинэ холболтын талаар мэдээлэлтэй гарын авлага, төлбөр тооцооны киоск цахим машин, Dtog.mn -ийн талаар мэдээлэл өгч оролцсон.




Цаг хугацаа хамаарахгүйгээр
Хэрэглэгч хүлээн авах төв дээр ирж
төлбөрөө төлж НӨАТ-ын баримтаа аваарай

Е-КИОСК
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛБӨР ТООЦООНЫ УХААЛАГ ШИЙДЭЛ
НЭВТРҮҮЛЛЭЭ

- 2022 онд төлбөр тооцооны киоск машиныг Дорнод салбар болон Сүхбаатар салбарын Хэрэглэгчдэд үйлчлэх төвд нэвтрүүлж, Qra үйлчилгээ 647, картаар 2693 хэрэглэгч 91.3 сая төгрөгийн төлбөр тооцоо төлсөн.

Хэрэглэгчийн аппликшн буюу Биллцентр-т хэрхэн нэвтрэх, биллер байгууллага холбох, цахилгааны кодоо баталгаажуулж бүртгэх, цахилгааны төлбөрийн дэлгэрэнгүйг харах, төлбөр төлөх, баримтаар и-баримт авах заавартай 26 секундний шторк бэлтгэж цахим хаягаар иргэдэд түгээсэн.




Хамрах хугацаа: 2022.12.20-2022.12.20

Холлогийн 2023-04-20 15:40

Д/д	Харгалзчийн код	Утасны дугаар	Мессеж	Имгээн зорио
1	401 7639	99940/70	DB608* Kod: 401 7639 Tani 70160.00 tug.amjiltra! tsahgilun Bayarlalaa, Noutun barmil. XN 6161****,Jen.70160.00 tug.balcenter am. Tel.70584771	7073-01-06 17.27.49



Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн <https://www.facebook.com/www.dtog.mn>
Хэрэглэгчдэд үйлчлэх төв – ДБЭХС ТӨХК facebook page хаяг, урсдаг самбар,
компанийн цахим хуудас [tps://ees.energy.mn/](https://ees.energy.mn/)-уудаар хэрэглэгчдэд цаг үеийн
мэдээ мэдээлэл, хөнгөлөлт чөлөөлөлтийн зурагт хуудас, эрчим хүчний
хэмнэлтийн талаарх бичлэг, зурагт хуудас, эрчим хүчний төлбөр тооцоо хэрхэн
барагдуулах тухай, шинэ жилийн мэндчилгээ зэрэг мэдээ мэдээллийг тогтмол
оруулж ажилласан.





7

ХАБЭА, БАЙГАЛЬ ОРЧИН ЭРҮҮЛ АХУЙ

Хөдөлмөрийн аюулгүй байдал

Үйлдвэрлэлийн ХАБЭА-н орчин нөхцөлийг сайжруулах, ажилтнуудыг ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл бусад эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласан..


Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйг хангах, ажилтныг аюул, эрсдэлээс хамгаалах, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах зорилгоор цех, хэсгүүдэд ХАБЭА-н байдалд тавих III шатны хяналтын үзлэгийг хагас жил тутамд нэг удаа удирдамжийн дагуу комисс ажилласан.



2022 онд улирал бүр компанийн хэмжээнд хийгдэх АЭД, ДҮТ-өөс ЭХНС-ийн хэмжээнд зохион байгуулдаг АЭД-ыг компани дээр зохион байгуулах зэрэг ашиглалтын ажилтнуудын аваар саатлын үед шуурхай ажиллах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлийн ажлуудыг тогтмол зохион байгуулсан.



2022 онд компанийн хэмжээнд хийгдсэн дасгалын тоон үзүүлэлтүүд




Дасгалын тоо	283	88	73
Хамрагдсан хүний тоо	3730	2926	2481

Жил бүрийн 4 дүгээр сарыг улс орон даяар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сар” болгон зарлаж, ХАБЭА-н тухай хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлуудыг зохион байгуулсан.

Энэ сарын аяны хүрээнд компанийн ажилтнуудын дунд ХАБЭА-н тухай хууль, ТАД, ААД, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дүрэм журам, хамтын гэрээг сурталчлан таниулах, ИТА, ажилтнуудын хууль дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “ХАБЭА-н ажил мэргэжлийн уралдаан” зохион байгуулсан.



“ДБЭХС” ТӨХК-ийн ажилтнуудын ХАБЭА-н хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг сайжруулах, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ХХ-ын хувцас нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн зөв өмсөж хэвшүүлэх зорилготой **“ТОЛГОЙ ХАМГААЛАХ”** сарын аяныг зохион байгуулсан.



Компанийн ХАБЭА-н 3 шатны үзлэгийн тоон үзүүлэлт



2022 онд ХАБЭА-н тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагууд, "Чадамжийн эрин академи"-ийн ХАБЭА-н сургагч багш хамтарч "Нийт ажилтнуудын ХАБЭА сургалт", "Шинэ ажилтнуудын ХАБЭА-н сургалт", "Даралтат сав шугам хоолойд ажиллах эрх олгох болон сунгах сургалт", "Оосорлогч дохиочин, өргөх зөөх механизмд ажиллах эрх олгох болон сунгах сургалт"-уудыг хийж ажилтнуудын ХАБЭА-н мэдлэг боловсролыг дээшлүүлэх, аваарь ослоос сэргийлэх, ХАБЭА-н зөв дадал зуршлыг төлөвшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулсан.





Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Дорнод аймгийн ОБГ, “ДБЭХС” ТӨХК-ийн хамтран ажиллах гэрээгээр ГАУС сургалт болон галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг жил бүр зохион байгуулдаг.

Дорнод аймгийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн, компанийн ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, гал түймрийг эсэргүүцэх тактик арга зүйг эзэмшүүлэх, аврах үйл ажиллагааг, осол эсэргүүцэх, гал эсэргүүцэх дасгал зохион байгуулсан.



Компанийн ажилтнуудад хор саармагжуулах бүтээгдэхүүнийг тогтмол олгож, 4 дэх жилдээ хэрэгжүүлж буй дархлаа дэмжих аяны хүрээнд улирал тутам нэг удаа, нийт ажилтанд хордлого тайлах, эрүүлжүүлэх бүтээгдэхүүн, чага мөөгний цай, дархлаа дэмжих септилин олгосон.

Байгаль хамгаалах чиглэлд:

Компанийн 2022 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг мэргэжлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлэн дүгнэлт гаргуулсан.



Ажлын байрны нөхцөл байдал /халуун, дуу чимээ, доргио/

Ажлын байрны температур /°C/



Ажлын байрны шуугиан /дБ/





Ажлын байрны гэрэлтүүлэг /лк/



Ажлын байрны агаарын харьцангуй чийглэг [%]



8

ДОТООД ХЯНАЛТ

ДОТООД АУДИТ

2022 онд Дотоод хяналтын албан нь төлөвлөгөөнд тусгагдсан 9 ажлыг гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд санхүү, хөрөнгийн бүртгэл, бараа материалын тооллогоор 17, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагааг хяналтын хуудсаар шалгах 7, тоолуурын лаборатори, хэмжүүр хэмжих хэрэгслийн нэгдмэл байдалд хяналт хийх 9, ЦЭХ-ний тариф, төрийн хөнгөлөлтийн хэрэгжилтийн 2, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих 4, Хөдөлмөр хамгааллын 3 дахь шатны үзлэг 21 зөвлөмж, албан даалгавруудыг өгч ажилласан.

ИЛ ТОД, ЁС ЗҮЙН БАЙДАЛ

Дотоод хяналтын алба нь “Шилэн дансны тухай хууль” “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.

Эрчим хүчний яамны 2022.02.24-ний Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дотоод аудитын тайланд дурдсан зөвлөмжийг Санхүү бүртгэлийн хэлтэс, Төлөвлөлтийн хэсэг, Хангамж үйлчилгээний хэлтэс, Захиргаа удирдлагын хэлтсийн холбогдох ажилтнуудад танилцуулсан. Тус тайланд компанийн 2021 оны Шилэн дансны тайлан 98.1% буюу III түвшинд гэж үнэлэгдсэн байна.



Компанийн нь шилэн дансны нэгдсэн сайтад 21 төрлийн мэдээллийг байршуулж, мэдээ, тайлангийн биелэлт 98.0% байна.



ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ



ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

ՀԱՅԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ
ԿՐԹԱՆՈՒՅՑԱԿԱՆ ԳԻՏՈՒԹՅԱՆ
ՄԻՆԻՍՏԵՐԱՆ

- Дотоод сүлжээ
- Мэдээллийн самбар
- Мэдээлэл түгээх дэлгэцүүд
- Компанийн цахим хуудас
- Телеграм зэрэг аливаа арга хэмжээ, үйл явдлын мэдээллийг цаг хугацаанд нь зураг, бичлэгтэйгээр боловсруулан компанийн цахим хуудсанд мэдээллийг оруулдаг.

9

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

“ДБЭХС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2022.01.04 ны өдрийн А/02 тоот тушаалаар Эрчим хүчний салбарын хэмжээнд “Нэг зуун мянган мод тарих” үйл ажиллагааны дагуу компанийн хэмжээнд зохион байгуулах, төсөв төлөвлөгөө гаргаж батлуулж ажиллах үүрэг бүхий комиссыг байгуулан ажилласан.

Эрчим хүчний салбарын хэмжээнд ирэх 10 жилийн хугацааны мод тарих төлөвлөгөөгөөр “ДБЭХС” ТӨХКомпани нийт 5,58 га талбайд 5580 ширхэг мод тарих ёстойгоос 2022 онд 1,139 га талбайд 6 төрлийн 3572 мод тарьсан.

Үүнд:

- Хайлаас 2950 ширхэг
- Улиас 162 ширхэг
- Шар хуайс 280 ширхэг
- Голт бор 92 ширхэг
- Нохойн хошуу 80
- Нарс 8 ширхэг

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилт, газрын доройтолтой тэмцэх арга хэмжээнд Эрчим хүчний салбараас “Зуун мянган мод” тарих үйл ажиллагааг зохион байгуулсан. Компанийн ажилтан албан хаагчид энэхүү хөдөлгөөнд идэвхтэй оролцож 05 дугаар сарын 07, 09 дүгээр сарын 28 ны өдрийн бүх нийтээр мод тарих өдрийг угтаж Дорнод Политехникийн коллежийн мэргэжлийн багш, Хэрлэн сумын ЗДТГазар болон “Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-ийн Баяннуур мод үржүүлгийн газартай хамтран заавар зөвлөгөө авч мод тарив.







10

ЧОЙБАЛСАН ДЦС-ЫГ 50МВт-ААР ӨРГӨТГӨХ ТӨСЛИЙН АЖЛЫН ЯВЦ

Төслийг хэрэгжүүлэгч:

Төслийн захиалагч: Эрчим хүчний яам

Захиалагчийн хяналт: Эрчим хүчний үндэсний төв

Ашиглагч байгууллага: “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

Ерөнхий гүйц этгэгч: БНХАУ-н “ТВЕА” компани

Гэрээ байгуулсан огноо: 2019.07.29

Төсөл хэрэгжих хугацаа: 2020.08.26-2023.06.30

Гэрээний нийт дүн: 79,488,266 ам.доллар

Улсын төсвийн санхүүжилт: 19,488,266 ам.доллар

МУХБанкны зээлийн санхүүжилт: 60,000,000 ам.доллар

Техникийн үзүүлэлт:

Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал: 50 МВт

Дулааны эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал: 100 Гкал

Төслийн зорилго

Зүүн бүс нутгийн өсөн нэмэгдэж буй цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээг хангах, тасралтгүй, найдвартай ажиллах, зах зээлд өрсөлдөх чадвартай, өндөр хүчин чадалтай станц болгох зорилготой.

Төслийн үндэслэл:

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь Монгол улсын зүүн бүс нутгийг хамарч үйл ажиллагаагаа явуулдаг ба Төвийн бүсийн нэгдсэн системээс тусдаа дангаар ажилладаг онцлогтой цорын ганц эх үүсвэртэй юм. 36 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай дулааны цахилгаан станц нь анх ашиглалтад орсноос хойш тасралтгүй 53 дахь жилдээ ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд Зүүн бүс нутгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ огцом нэмэгдэж ЦЭХ-ний хэрэглээг бүрэн хангах боломжгүй болсон тул 2015 оноос эхлэн өвлийн их ачааллын хугацаанд Сүхбаатар аймгийн хэрэглэгчдийг төвийн бүсийн эрчим хүчний системд шилжүүлэн, ачаалал хөнгөлөн, станцын үндсэн тоноглолууд бэлтгэлгүйгээр ажиллуулж байна. Мөн станцын цахилгааны оргил ачаалал суурилагдсан хүчин чадлаас давж 38,6 МВт хүрч цаашид бүс нутгийн ЦЭХ-ний өсөлтийг тогтвортой хангах боломжгүй болсон.

Иймд бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хаахын тулд Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөл хийх зайлшгүй шаардлага үүссэн.

Төслийн хэрэгжилтийн явц:

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхээр БНХАУ-ын ТБЕА компанитай 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр ЭХА-012/2019 тоот гэрээ байгуулсан.





Барилга угсралтын ажил:

2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар төслийн ерөнхий барилга угсралтын ажлын гүйцэтгэл 54 хувьтай байна.

Үүнд:

- Зураг төсөл- 100 хувь
- Тоног төхөөрөмж үйлдвэрлэл-96 хувь
- Төслийн барилга угсралт-35 хувь
- Тоног төхөөрөмж тээвэрлэлт- 38 хувь
- Тоног төхөөрөмж зүгшрүүлэлт-0 хувь



Төслийн барилга угсралтын ажлыг 2022 оны 07 дугаар сарын 18 өдрөөс эхлүүлж дараах гол ажлуудыг гүйцэтгэсэн.

Үүнд:

1. Яндангийн "0" түвшнээс дээш 21 метр хүртэлх арматур зангидах, хэв угсрах, бетон цутгалтын ажил хийгдэж дууссан.
2. Зуухны барилгын 1-5 дугаар үеийн төмөр бүтээц (нийт 53 метрийн өндөр) угсрах ажил хийгдсэн. Мөн зуухны тогоо болон агаар халаагчуудыг суурилуулсан.
3. 110кВ-н хаалттай хуваарилах байгууламжийн аяган суурийн цутгалт бүрэн дуусгаж, нүх буцаан булах, хөрс нягтруулах ажил хийгдсэн.
4. Турбогенераторын 0 түвшнээс дээш +8м хүртэлх төмөр бетон суурийг хийж дуусгасан.
5. Оффисын барилгын суурийн цутгалт бүрэн дуусгаж, нүх буцаан булах, хөрс нягтруулах ажил хийсэн.
6. Нүүрс бутлуурын байрны суурийн бүтээцийн ажлыг бүрэн дуусгаж, коннейвер №2-н +7,04м түвшин хүртэлх их биеийн цутгалтын ажил дууссан.
7. Деаэратор болон нүүрсний бункерийн барилгын 1 дүгээр давхрын +4,45м түвшин хүртэлх бетон цутгалтын ажил дууссан. 2 дугаар давхрын барилгын шат угсрах ажлыг хийсэн.
8. Нэгдсэн усан сангийн шалны бетон цутгалтын ажлыг дуусгаж, 0 түвшин хүртэлх ханын арматур зангидах ажил хийгдсэн.
9. Хөргөх цамхгийн 5 үеийн бетон цутгалтын ажил дууссан. Хөргөх цамхаг дотор 0 түвшнээс дээш 12м өндөрт бороожуулах төхөөрөмжийн тулгуур багана, дам нуруу суурилуулах ажил дууссан.
10. Эргэлтийн усны шугам хоолойн угсрах ажил хийгдсэн.

Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлт:

БНХАУ-д зуухны тоног төхөөрөмж үйлдвэрлэл 100 хувь, турбины тоног төхөөрөмж үйлдвэрлэл 100 хувь, генераторын тоног төхөөрөмж үйлдвэрлэл 100 хувь туслах тоноглолын төхөөрөмж үйлдвэрлэл 80 хувь, трансформатор 100 хувь тус тус үйлдвэрлэсэн байна. Нийт тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн гүйцэтгэл 96 хувьтай байна.





Тоног төхөөрөмж бараа материалын тээвэрлэлт:

2022 онд 194 машин нийт 316 авто машин тоног төхөөрөмж, бараа материал төслийн талбайд ирсэн. Үүнд:

- Зуухны тоног төхөөрөмжүүд 95 хувь
- Турбины тоног төхөөрөмжийн 65 хувь
- Цахилгааны тоног төхөөрөмжийн 35 хувь
- Туслах тоног төхөөрөмжийн 30 хувь тус тус төслийн талбайд ирээд байна.

Мөн төслийн үндсэн тоноглолууд үйлдвэрлэгдэж дууссан тул 300 гаруй машин тоног төхөөрөмж үйлдвэр дээр, 70 машин тоног төхөөрөмж БНХАУ-н Эрээн хотод тээвэрлэгдэн ирж хилээр нэвтрэхэд бэлэн хүлээгдэж байна.



ТӨСЛИЙН ТАЛБАЙД

Зуухны тоног төхөөрөмж	Турбины тоног төхөөрөмж	Цахилгааны тоног төхөөрөмж	Туслах тоног төхөөрөмж
95%	65%	35%	30%

Хүн хүч:

2022 онд БНХАУ-н 95 инженер техникийн ажилтан, Монгол улсын 171 ажилтан нийт 266 ажилтан, 15 гаруй тусгай үүрэг зориулалтын машин механизм ажилласан.

ТӨСЛИЙН ТАЛБАЙД



171 ажилтан



95 ажилтан



ТУСГАЙ
ЗОРИУЛАЛТЫН
МАШИН
МЕХАНИЗМ

15

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС “ДБЭХС” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТЭД
ӨГСӨН ҮНЭЛГЭЭ.**

Тусгай зөвшөөрлийн төрөл	2021 он	Үнэлгээ	2022 он	Үнэлгээ
Цахилгаан, дулаан үйлдвэрлэх	93.3	Хангалттай сайн	87.9	Сайн
Цахилгаан түгээх	85.7	Сайн	78.6	Сайн
Цахилгаанаар зохицуулалттай хангах	80.4	Сайн	83.6	Сайн

“ДБЭХС” ТӨХК нь 2022 онд:

- Аваари, I, II зэргийн саатал гаргаагүй.
- ДХЦЭХ ний хувь хэмжээг зорилтот түвшнээс 0.64 нэгжээр хэмнэснээр 1,559.9 мян кВтц цахилгаан эрчим хүч хэмнэсэн.
- Жишмэл түлшний хувийн зарцуулалтыг цахилгаанд 34.6 гр/кВтц, дулаанд 1.6 кг/Гкал аар тус тус бууруулснаар нийт 6,624.0 т ж т буюу 20.3 мянган тонн нүүрс хэмнэсэн.
- Компанийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол Дорнод аймгийн Баяндун суманд цахилгааны монтор хүчдэлд нэрвэгдсэн 1 бүртгэгдсэн.
- Цахилгаан түгээлтийн алдагдлыг 2022 онд мөрдөх зорилт шинийн түгээлт хассан дүнгээр 7.90% д барьж ажилласан.
- Борлуулалтын орлогод шаардагдах хэмжээ тарифт тооцсоноос 3,593.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ



"ДЭЭХС" ТӨХК, Чойбалсангийн гудамж
1-р байр / Дорнод аймаг, Хэрлэн сум, /Т/х: 21065

Утас: (976) 7058 4545, (976) 7058 4547

Факс: (976) 70584545

Цахим хант: info@ees.energy.mn

Вэб хуудас: www.ees.energy.mn